

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ



**ЕСӨНЗҮЙЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА Т.НАРАНГЭРЭЛ

Мөнхбулаг
2024 он

ЁСӨНЗҮЙЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2024 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.21

Мөнхбулаг

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн буюу хэрэгжилт /хэрэгжилт хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт - гэлийн хувь
<p align="center">Стратеги зорилго 1: Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, салбарын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нутаг дэвсгэр дэх хүн амыг соён гэгээрүүлэх зорилгын хүрээнд</p>							
<p align="center">Зорилт: Нэг. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд</p>							
1.1	<p>Уламжлалт зан заншил, ахуй соёл, тоглоом наадгайг сурталчилан Нүүдэлчин ахуй, арга хэмжээ зохион байгуулах, СТХ-ийн 21.1.11, МУЗГ-ын 2.6.2.2, АҮЧ-ийн 1.1.1.1</p>	<p>Улсын төсөв, хандив 100.000₮</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор</p>	-	2 үйл ажиллагаа зохион байгуулна.	<p>Монголын өв соёл, Үндэсний уламжлалт “Шагайн наадгай” тэмцээнийг ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж багийн мэндчилгээ, морь уралдуулах, шагай шүүрэх, шагай няслах гэсэн 4 үе шаттайгаар зохион байгуулж, Тэргүүн байр, дэд байрыг тус тус шалгаруулсан бөгөөд тэмцээнд 10-12 дугаар ангийн нийт 48 сурагч оролцсон байна. Мөн Орон нутаг судлах танхимд 2024 оны байдлаар давхардсан тоогоор 150 гаруй иргэд болон ЕБС-ийн сурагчид үйлчлүүлсэн бөгөөд тэдгээрт уламжлалт зан заншил, ахуй соёлтой холбоотой тоглоом наадгайг сурталчилж, музейн үйлчилгээг үзүүлж ажилласан байна.</p>	90 %

1.2	<p>“Иргэдийн идэвхийг сайжруулах соён гэгээрүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлж, Намрын номын баяр, “Эртэч оюунлаг Ёсөнзүйлчүүд” гэх мэт) СТХ-23 дугаар зүйл МУЗГҮАХ-2.6.2.2, ССГ-2.1, 2.2 ЗДҮАХ-1.1.1.2</p>	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2024оны эхний хагас жилд 8 үйл ажиллагаа зохион байгуулсан	4үйл ажиллагаа зохион байгуулна.	<p>Намрын номын баяртай холбогдуулан дараах үйл ажиллагааг зохион байгуулсан Үүнд: 1.Зөврийн номын сан /Номын санд ирж үйлчилгээ авах боломжгүй хөдөөгийн иргэдэд номын сангийн үйлчилгээг 7 өрхийн 11 иргэнд / үзүүлсэн. 2. Хүрэл тулга ЕБС-ийн ахлах дунд ангийн нийт 11 сурагч оролцсон. 3. Өглөөний номын унцлагад ЗДТГ, ЭМТ СӨБ ЕБС Соёлын төв зэрэг байгууллагын 61 ажилтан албан хаагчдыг хамруулж ажилласан байна.</p>	90%
Бүлгийн дүн:							90%
Зорилт: Хоёр. Иргэдийн амралт, чөлөөт цаг, баяр ёслолд зориулсан соёлын олон талт арга хэмжээ зохион байгуулах, соён гэгээрүүлэх, соёлын нүүдлийн үйлчилгээ хүргэх							
2.1	<p>Номын сангийн үндсэн болон туслах үйлчилгээг өргөжүүлж, “Номын баяр-2024” арга хэмжээнд оролцох СТХ-4.1.2, 14.2.1, ССГ-2.7 ЗДҮАХ-1.1.1.2,1.1.3.3 АҮЧ-ийн 1.1.1.9</p>	Улсын төсөв 700.000₮	Үйлчилгээний төрөл, нэмэгдсэн номын тоо, цахимжуулсан номын тоо, үйлчлүүлэгч, шинэ уншигчийн тоо	Фонд 5000 ном, үйлчлүүлэгч 266, шинэ уншигч 98 Шинэ ном 25	Фонд 5050 ном, үйлчлүүлэгч 300, шинэ уншигч 34 Шинэ ном 50	<p>Номын сангийн сан Lib4u программд номын сангийн сан хөмрөгт бүртгэлтэй 5000 номыг бүртгэж, шинээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.000,000₮-ийн төгрөгийн үнэ бүхий 34 ширхэг уран зохиолын болон хувь хүний хөгжлийн номыг худалдан авч номын сангийн фондоо баяжуулсан бөгөөд мөн Lib4u программын нэг жилийн хураамж болох 330.000₮-ийг тогтмол төлдөг. 2024 оны байдлаар номын сангийн уншигчийн тоо 272,Ирэгсэд 781 гэсэн үзүүлэлттэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.</p>	90%

2.2	Номын сангийн LIB4U программыг нэвтрүүлж иргэд эрэлт хэрэгцээтэй номоо сонгоход хялбар болгох	Байгууллагын төсөв	Программд бүртгэсэн номын тоогоор	4771	5000	Lib4u Программд номын сангийн сан хөмрөгт байгаа 5000 номыг 100% бүртгэсэн байна.	100%
2.3	Соёлын төвийн дугуйлангуудын чанар хүртээмжийг дээшлүүлж сурагчдын тоог нэмэгдүүлнэ СӨХТХ-39.3, ССГ-4.8,ЗДҮАХ- 1.1.2.2	Улс, орон нутгийн төсөв 1.000,000₮	Дугуйланд заагдах уран бүтээлийн цар хүрээ, сурагчдын тоогоор	Бүжиг-35 Уртын дуу-42 Аман өв-2	Бүжиг-40 Уртын дуу-50 Аман өв-3	Бүжгийн дугуйланд 42 сурагч Уртын, дууны дугуйланд 45 сурагч, Аман өвийн дугуйланд 3 сурагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр долоо хоног бүрийн цагийн хуваарийн дуагаа дугуйлангууд хичээллэж байна.	100%
2.4	"Мэдээллийн цаг" арга хэмжээг албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд зохион байгуулна.	Байгууллагын төсөв	Хамрагдсан албан байгууллагын тоогоор	ЕБС, ЭМТ-ийн хамт олон оролцсон	Бүх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд мэдээлэл хүргэж оролцсон байна.	Мэдээллийн цаг үйл ажиллагаанд ЕБС, ЭМТ-ийн ажилтан албан хаагчид байгууллагынхаа үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэсэн. Мөн урлагийн номер, нийтийн цэнгээнт бүжгийг зохион байгуулсан бөгөөд тухайн арга хэмжээнд нийт 43 иргэд олон нийтийг хамруулж ажиллаа.	100%
2.5	Баасан гараг бүр нийтийн бүжиг зохион байгуулах	-	Хамрагдсан иргэдийн тоогоор	Нэг удаагийн бүжигт 30-40	Нэг удаагийн бүжигт 40-60	Баасан гараг бүр нийтийн цэнгээнт бүжгийг зохион байгуулж ард иргэд болон ААН, албан байгууллагын ажилтан албан хаагчдыг идэвхтэй хамруулж байгаа бөгөөд 2024 оны байдлаар давхардсан тоогоор 800 гаруй иргэдийг хамруулж ажилласан байна.	100%
2.6	Баяр наадмын урлаг, соёлын үйл ажиллагааг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Сумын наадамд оролцогчдын тоо	-	200-300	Баяр наадмын нээлт болон хаалт хүртэлх наадмын талбайд болон Соёлын төвд зохион байгуулагдах бүх	100%

	НТБТӨТХ-4.1.1 ССГ-3.5					арга хэмжээнд соёл урлагийн номеруудыг танилцуулж, мөн бөхийн комисст бүжгийн багш Ж. Батсайхан, морьны комисст, хөгжмийн багш М. Эрдэнэ- Очир, зохион байгуулах комисст дарга Т. Нарангэрэл нар тус тус ажилласан байна.	
2.7	Бүжгийн дугуйлангийн сурагчдын тайлан тоглолт хийх	Байгууллагын төсөв 60.000₮	Зохион байгуулсан тоглолтын чанар, үзэгчдэд хүрсэн байдлаар	2023 онд хийгээгүй	Бүжгийн багш өөрийн дэглэсэн 2 бүжиг. зрител дүүрэн тоглоно.	Бүжгийн багш Ж.Батсайхан нь монгол ардын бүжиг, чөлөөт бүжиг, болон орчин үеийн бүжгийн урлагийн чиг хандлагад нийцүүлэн 26 номер бүхий Соёлын төвийн дэргэдэх "Есөн цацалз" бүжгийн дугуйлангийн сурагчдын "Урлан бүжихүй анхны бие даасан тайлан тоглолтыг амжилттай зохион байгуулж ажиллаа.	90%
2.8	Уртын дуу, Аман өвийн дугуйлангийн тоглолт	Байгууллагын төсөв 180.000₮	Зохион байгуулсан тоглолтын чанар, үзэгчдэд хүрсэн байдлаар	2023 онд хийгдээгүй	Айзам уртын дуу заасан байх.	Уртын дууны багш Т.Нарангэрэл нь Бэсрэг, айзам нийлсэн 13 уртын дуунаас бүрдсэн хөтөлбөр бүхий уртын дууны дугуйлангийн сурагчдын "Энх мэндийн баяр" 3 дахь удаагийн бие даасан тайлан тоглолтыг амжилттай зохион байгуулж ажиллаа.	100%
2.9	Цахим соёл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ERP, E-Mongolia систем, тоон гарын үсэг нэвтрүүлэх, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, интернэт	-	Маягтаар бүрэн хугацаандаа явуулсан мэдээ, тайлангийн тоо, хувь, тоон гарын үсэг хэрэглэж хэвшсэн	2023 онд цахимаар илгээсэн мэдээ тайлангийн тоо, тоон гарын үсэг хэрэглэж хэвшсэн албан хаагчдын тоо	Бүх албан хаагчид тоон гарын үсэг ашиглаж хэвшсэн байх.	Бүх ажилтан албан хаагчид тоон гарын үсэг ашиглаж хэвшсэн, байгууллагын дотоод сүлжээний ERP системийн эрхийг дарга Т.Нарангэрэл авч анхан шатны сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч байгаа. Мөн байгууллагын цахим хаяг болох /Есөнзүйл Сум Соёлын Төв/ хуудсаар дамжуулан соёл урлагийн болон бусад олон талт үйл ажиллагааны	100%

	сүлжээний нэгдсэн зохион байгуулалтад орлуулах МУЗГ-ын 216 дугаар тогтоол 2.3		албан хаагчдын тоо			мэдээ мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна.	
Бүлгийн дүн:							98%
Зорилт: Гурав. Өвөрхангай аймгийн Засаг даргаас Есөнзүйл сумын Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ							
3.1	“Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөдөөгийн иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Байгууллагын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Эхний хагас жилд 3	3	Мөсний баяр, Сар хайрханы тахилга наадам, Аймгийн аврага шалгаруулах адуучин тэмцээн, Дэмчиг толгойн тахилга наадам, Улсын аврага малчдын мялаалга наадам мөн бусад олон төрлийн цолны мялаалга наадмуудад нийт давхардсан тоогоор 2500 орчим иргэнд соёл урлагийн үзвэр үйлчилгээг үзүүлж ажилласан.	100%
3.2	Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулах	-	Тооллого зохион байгуулагдсан байна.	-	-	Өндөр Гэгээн Занабазарын Номын өргөөнд хадгалагдаж байсан зулын цөгц, Сумын Гандан хийдэд хадгалагдаж байсан Алтан ганжуур судар, эрт үеийн даавуун бурханы зургуудыг бүртгэлд оруулсан.	100%
Бүлгийн дүн:							100%
Зорилт: Дөрөв. Соёлын биет болон биет бус өвийн бүртгэн баримтжуулалтыг нэмэгдүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, сурталчилан таниулах зорилтын хүрээнд							
4.1	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын тоог	Байгууллагын төсөв	Нэмэгдсэн иргэдийн тоогоор	2023 онд биет бус өвийн	2-3	2024 оны онд биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо 3-аар нэмэгдэж Соёлын төвийн биед бус өвийг өвлөн	100%

	нэмэгдүүлж бүртгэл мэдээллийн санг баяжуулна СТХ-ийн 9.1.1, АҮЧ-ийн 1.1.1.3, ЗДҮАХ-ийн 1.1.1.6			өвлөн уламжлагч 6		уламжлагчдын санд шинээр бүртгэгдсэн. Мөн Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан Ерөөлч, магтаалчдын аймгийн анхдугаар уралдаанд Б.Баасанцэрэн, Б.Алтанцэцэг, Ц.Паламбанди нар оролцож өвлөн уламжлагчдынхаа үнэмлэхийг гардан авсан. Мөн тус уралдаанд: 8-13 насны ангилалд ЕБС-ийн 66 ангийн сурагч Б.Баасанцэрэн III-р байр, 40-с дээш насны ангилалд IV-р багийн малчин Ц.Паламбанди III-р байрт тус тус шалгарсан амжилт үзүүлсэн байна. Мөн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Зууны манлай уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 120 жилийн ойд зориулсан "Дуртмал сайхан" уртын дууны уралдаанд 3 есвөрийн уртын дуучин амжилттай оролцож шилдэг 10 хүүхдэд шалгарсан.	
4.2	Орон нутаг судлах танхимын үзмэрийн тоог нэмэгдүүлэх АЗДҮАХ-1,1,2,4	Орон нутгийн төсөв	Нэмэгдсэн үзмэрийн тоогоор	-	2-3	Сумын иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч Г.Цэрэндулам 1930 -аад оноос хойш ашиглагдаж байсан гар оёдлын машинаа орон нутаг судлах танхимд өгсөн. Мөн ЗДТГ-аас Бурхан бумбын орон Уран зургийн галерейд 1 гар зургийг хүлээлгэн өгсөн	100%
Бүлгийн дүн:							100%
Зорилт: Тав. Албан Хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд							

5.1	Ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	Байгууллагын төсөв	Хүний тоо	2 ажилтан, албан хаагч үзлэг шинжилгээ хийлгэсэн	4 ажилтан албан хаагч үзлэгт хамруулах	2024 онд 2 ажилтан албан хаагч эрт үлрүүлгийн шинжилгээнд хамрагдсан.	90%
5.2	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, сургалт хөгжлийг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах СТХ-ийн 11.4.3, АЗД-ын захирамж а/113	Улсын төсөв, томилолт	хамрагдсан хүний тоогоор	2023 онд 3 албан хаагч	Хөгжмийн багш, бүжгийн багш, бичиг хэргийн ажилтанг мэргэшүүлэх сургалтанд хамруулах	Соёл урлаг, Аялал жуулчлал, Залуучуудын яам болон Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театрын хамтарсан хөгжим, техник тоног төхөөрөмжийн талаар ур чадвар олгох сургалт, СУИС-д зохион байгуулагдсан техник, тоног төхөөрөмжийн анхан болон ахисан шатны ур чадвар олгох сургалтад хөгжмийн багш М. Эрдэнэ-Очир танхимаар хамрагдсан, Нягтлан бодогч нарын чадавхжуулах сургалтад Ня-бо Б.Азсүрэн танхимаар хамрагдсан, Сити Их Сургуулиас зохион байгуулсан Соёлын боловсролын талаар хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалтад бүх ажилтан албан хаагчид цахимаар, гэх мэт хэрэгцээ шаардлагатай сургалтуудад хамрагдаж ажилласан байна. Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааны хүрээнд 2024 онд Номын санч, мэдээллийн ажилтанд амаржсаний тэтгэмж, Архив, бичиг хэргийн ажилтанд амаржсаны тэтгэмж, шүүнээр гэр бүл болсон номын санч, мэдээллийн ажилтанд мөнгөн тэтгэмж, нийт ажилтан албан хаагчдад үр дүнгийн урамшуулал зэргийг тус тус олгож	100%

						нийт 2.950,000₮-ийг зарцуулсан байна.	
Бүлгийн дүн:							95%
Зорилт: Зургаа. Байгууллагын тохижилт, бүтээн байгуулалт							
6.1	Өрөө тасалгааны зохион байгуулалт хийж, хүүхдийн өрөөний тохижилтыг сайжруулах	Орон нутгийн төсөв	Тохижуулсан өрөө тасалгааны тоогоор	2023 онд тохижилт хийгдээгүй	Хөгжим,бүжгийн заал, хүүхдийн өрөө, уртын дууны танхим	Бүжгийн өрөө, хөгжмийн өрөө, хүүхдийн өрөө тасалгаануудад үйл ажиллагааны чиглэлд нь тохирсон акустик хавтан ашиглан тохилог ая тухтай орчныг бүрдүүлж мөн номын санд UB хавтан ашиглан номын 3 ширхэг тавиур зэрэг тохижилтын ажил үйлчилгээг хийж ажилласан байна.	100%
6.2	Үзэгчдийн танхимын шал будах	Орон нутгийн төсөв	Гүйцэтгэлээр	2023онд будаагүй	Заалны шалыг будсан байх	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болох 750,000₮-ийн санхүүжилтээр Үзэгчдийн танхим болох заалны шалыг будсан байна.	100%
Бүлгийн дүн:							100%
Зорилт: Долоо. Хөрөнгө оруулалт							

Зорилт: Долоо. Хөрөнгө оруулалт


7.1	Соёлын яамнаас шаардлагатай техник тоног төхөөрөмж	Улсын төсөв	Техник тоног төхөөрөмжийн тоогоор	2023 оны хөрөнгө оруулалт	-	Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 8.174,422₮-ийн Суурин компьютер, Зөөврийн компьютер, Даралтат хөгжим зэрэг хэрэгцээ шаардлагатай техник, төхөөрөмжийн хангалт хийгдсэн.	100%
7.2	Акустик доторлогоо, тохижилтын ажил хийх	ОНХСан 20.000,000₮	Гүйцэтгэлээр	2023 онд тохижилт хийгдээгүй	Үзэгчдийн танхим буюу зааланд акустик доторлогоо, тохижилт хийх	Орон Нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19.706,000₮-ийн акустик доторлогоог 2024 оны 09 сард "Индранил засал чимэглэл ХХК"-аар хийж гүйцэтгүүсэн.	100%
Бүлгийн дүн:							100%
Нийт дүн:							98%

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН:
СУМЫН ЗАСАГ ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг



ТӨСВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАГЧ
Ц. МЯГМАРСҮРЭН

2024.12.10

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Т.НАРАНГЭРЭЛ

2024.12.10